

Монгол төрөл хэлний үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэлШҮРЭНХҮҮ¹

БНХАУ-ын ӨМӨЗО, Хөх хот,

Өвөр Монголын Их сургуулийн Монгол судлалын дээд сургууль

***Хураангуй:** Монгол төрөл хэл болох баоань, монгор, зүүн ёгор, дуншаан хэлний өргөлт голдуу үгийн эцсийн үед илэрдэг. Энэ нь үгийн эхний эгшиг гээгдэж нийлмэл гийгүүлэгч үүсэх үзэгдлийг бий болгожээ. Үгийн эхний эгшиг гээгдэхэд эгшигийн аниришил, тухайн эгшигтэй холбогдол бүхий хамрын гийгүүлэгч, хамжих гийгүүлэгч, хамжин шүргэх гийгүүлэгч болон үгийн өргөлтийн байр чухал. Монгол хэл ба дагуур хэлний үгийн өргөлт ихэнхдээ нэгдүгээр үед байдаг учир үгийн эхнээс эгшиг гээгдэх үзэгдэл тун цөөн байдаг. Ер нь түрэг төрөл хэлний үгийн өргөлт мөн үгийн адагт илэрч үгийн эхний эгшиг гээгддэг бол манж тунгус төрөл хэлний үгийн өргөлт утга ялгах үүрэгтэй байж үгийн эхний эгшиг гээгддэггүй. Алтай язгуур хэлний үгийн өргөлтийг орон зайн байршил талаас шинжилж үзвэл, ерөнхийдөө зүүнээс барууни газар зүйн чиглэл дагуу өргөлтийн байр нь үгийн эхний үеэс эцсийн үе рүү шилжсэн байна. Үүний дагуу алтайн язгуур хэлний үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл ч зүүнээс баруун тийш аажмаар нэмэгдсэн тухай төрөл хэлний баримтаар нотлон тус өгүүллийг бичив.*

***Түлхүүр үг:** монгол төрөл хэл, үгийн эхний эгшиг, өргөлт, гээгдэх үзэгдэл*

Vowel Deletion in Word-Initial Syllables in Mongolic Languages

SHURENKHUU

Institute of Mongolian Studies, Inner Mongolia University,

Hohhot, Inner Mongolia, China

***Abstract:** In several Mongolic languages namely Baoan, Mongor, Eastern Yogor, and Dungxiang lexical stress predominantly falls on the word-final syllable. This stress pattern has led to the deletion of vowels in word-initial syllables, resulting in*

¹ © Шүрэнхүү, 2025

Email: xirihu@126.com

the formation of consonant clusters. In the process of word-initial vowel deletion, vowel weakening, consonantal properties, and stress placement play crucial roles.

The placement of stress on the final syllable in Baoan, Mongor, Eastern Yogor, and Dungxiang is the result of language contact and influence from Turkic languages. This contact-induced change has produced areal convergence among different Mongolic languages. In Turkic languages, stress typically falls on the final syllable, and word-initial vowel deletion is relatively widespread. By contrast, in Mongolian proper and Dagur, stress most often occurs on the first syllable, and word-initial vowel deletion is therefore rare. Furthermore, in Tungusic languages, stress has a contrastive (lexically distinctive) function, and word-initial vowels are almost never deleted.

These observations suggest that, across the so-called Altaic languages, stress placement tends to shift geographically from word-initial syllables in the east to word-final syllables in the west, and that the degree of word-initial vowel deletion increases correspondingly along this east–west axis.

Keywords: *Mongolic languages; word-initial vowels; vowel deletion, stress*

1. Удиртгал

Монгол төрөл хэл цаашилбал алтайн язгуурын хэлэнд үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл түгээмэл оршино. Энэ нь үгийн өргөлттэй холбоотой (Чен Най Шиөн, 1995: 432). Монгол хэл болон дагуур хэлний үгийн өргөлт нэгдүгээр үед байж, монгор, дуншаан, баоань хэлний өргөлт үгийн эцсийн үед оршдог бөгөөд түрэг төрлийн хэлнүүдийн үгийн өргөлттэй адил гэж үздэг. Монгол төрөл хэлний өргөлтийн адил бус байр нь үгийн эхний эгшгийн гээгдэх үзэгдэл харилцан адилгүйг харуулж байна. Үүнд тухайн эгшгийн аниршил, жич холбогдох гийгүүлэгчийн шинж чанар зохих нөлөө үзүүлж байна.

2. Судалгааны арга зүй

Тус өгүүлээр монгол төрөл хэлний үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдлийг олон хэлний жишээ баримтаар батлан, гээгдэх нөхцөл шалтгааныг тодорхойлох зорилготой. Үүний тулд дараах зорилтыг дэвшүүлэв. Монгол сурвалж бичиг болон алтайн төрөл түрэг, манж түнгүс хэлний өргөлт болон үгийн эхний эгшгийг авч үзнэ. Үүгээр дамжуулан алтайн язгуурын хэлний үгийн өргөлт газар зүйн чиглэл дагуу хэрхэн хувирч буйг үгийн эхний эгшгийн гээгдэх үзэгдлээр тодорхойлно. Тус өгүүлэлд тодорхойлон бичих аргыг хэрэглэж баоань, монгор, дуншаан, зүүн ёгор, дагуур, монгол хэлэнд үгийн эхний эгшиг гээгдсэн үзэгдлийг авч үзнэ. Түүхэн харьцуулсан аргаар монгол төрөл хэлнүүдийн үгийн эхний эгшгийн гээгдэх байдлыг хооронд нь харьцуулан шинжилж эл хэлнээ үгийн эхний эгшиг гээгдсэн хэмжээ, жич нөхцөл боломжийг тодорхойлно. Мөн монгол төрөл хэл, түрэг төрөл хэл ба манж түнгүс төрөл хэлний үгийн өргөлтийн байраас шалтгаалсан үгийн эхний эгшгийн байдлыг шинжилнэ. Тооцоолох аргаар эдгээр хэлний үгийн эхний эгшиг гээгдсэн давтамжийг гаргаж, хувийг тогтоон, улмаар эдгээрийн дарааллыг

тодорхойлно. Үүний дагуу авианы дуун ухааны задлалын дүнд илэрсэн үгийн эхний эгшгийн авианы хүчдэлийн хэмжээгээр асуудлыг батална. Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн Чен Най Шиөн -ийн "Баоань хэлний үгс" (1986), Хасбаатар нарын "Монгор хэлний үгс" (1986), Булчулуу нарын "Зүүн ёгор хэлний үгс" (1986), Бөхөө нарын "Дуншаан хэлний үгс" (1983), Энхбатын "Дагуур хэлний үгс" (1984) зэрэг бүтээлийг хэрэглэгдэхүүн болгов.

3. Монгол төрөл хэлний үгийн эхний эгшиг

Монгол төрөл хэлэнд баоань, монгор, дуншаан, зүүн ёгор, дагуур, монгол зэрэг хэл багтана. Эдгээр хэл нь хэдийгээр адилхан нэг төрөл хэлэнд багтах боловч үгийн эхний эгшгийн авиалах байдал нь хоорондоо ялгаатай. Үүнд, дагуур хэлэнд үгийн эхний эгшиг бүрэн хадгалагдаж байхад монгол хэл аялгуунд үгийн эхний эгшиг баларч гээгдэх үзэгдэл хааяа илэрдэг. Харин баоань, монгор, зүүн ёгор хэл болон дуншаан хэлэнд үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл түгээмэл. Энэ нь хэлнүүдийн өргөлтийн байр харилцан адилгүйтэй шууд холбоотой юм.

3.1. Баоань хэл

Баоань хэлний нянтуг аялгуу а,э,е,и,ө,у зэрэг 6 эгшигтэй. Эдгээр эгшиг үгийн эхэнд олонтоо гээгддэг тул үеийн бүтцээр нь ерөнхийд нь дараах байдлаар ангилж болно.

3.1.1. Эгшиг(Э) бүтцэт үе гээгдэл

Баоань хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
na:-	ɒna:-	una-	уна-
ɣer	ɛxɣ	oxor	охор
seŋ	usɛn	üsün	үсэн
raxə	ærx	arixi	архи
rə-	ir-	ire-	ир-

3.1.2. Эгшиг гийгүүлэгч (ЭГ) бүтцэт үеийн эгшиг гээгдэл

Баоань хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
ndaɣ-	ɒnda:s-	umdagas-	ундаас-
ʂgel-	oʂgol-	isxül-	өшиглө-
mba-	ɒmba-	umba-	умба-

3.1.3. Гийгүүлэгч эгшиг (ГЭ) бүтцэт үеийн эгшиг гээгдэл

Баоань хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
nda:nɔŋ	nidnan	nidunun	ноднин
ʂgɔ	sux	süxe	сүх
ɦɕa-	xoʈf-	xuɕa-	хуч-

ʂda-	ʃad-	čida-	чад-
ḡgu-	ux-	ükü-	үх
ḡda:	o:t	uguta	уут

3.1.4. Эгшиг гийгүүлэгч буюу гийгүүлэгч эгшигт бүхэл үе гээгдэл

Баоань хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
ge-	edge-	edege-	эдгэ-
dalda-	xudald-	xudaldu-	худалд-
se	bus	büse	бүс
le᠋ᠭ	söl᠋ᠭᠭ	solongga	солонго
çi	biʃ	biši	биш
ta:-	ont-	unta-	унт-

Баоань хэлэнд үгийн эхний эгшиг гээгдсэн үг 46 илэрчээ. Үеийн түвшнээр задалбал ганц эгшиг бүтцэт үеийн эгшиг 13(28.2%) үгэнд, эгшиг гийгүүлэгч бүтцэт үеийн эгшиг 2 (4.3%) үгэнд, гийгүүлэгч эгшигээр бүтсэн үеийн эгшиг 20 (43.4%) үгэнд, гийгүүлэгч эгшигт үе бүхлээр гээгдсэн нь 8 (17.3%) үгэнд илэрчээ. Эдгээр тоо баримтаас үзвэл гийгүүлэгч эгшигт үеийн эгшиг хамгийн их гээгдэж бүх үгийн 43.4%-г эзэлж байгаа нь үгийн эхэнд нийлмэл гийгүүлэгч бүрэлдэх нөхцөлийг бий болгожээ. Нэн дурдууштай нь *dalda*, *se*, *le᠋ᠭ*, *la᠋ᠭ*, *ta:* зэрэг 11 үгэнд гийгүүлэгч эгшигээр бүтсэн бүхэл үе гээгдэж бүх үгийн 23.9%-г эзэлсэн байна. Энэ нь баоань хэлний үгийн эхэнд дан эгшгийн гээгдлээс бүхэл үе гээгдэх зүг шилжсэн эгшгийн гээгдэл тун идэвхтэй байгааг харуулж байна.

Баоань хэлний үгийн өргөлт эцсийн үед байдаг тухай эрдэмтдийн санал үндсэндээ нэгдмэл байдаг. Үүнд, Дээжхүү баоань хэлний эгшиг авианы дууны задлал хийж хоёр үет үгийн хоёрдугаар үеийн эгшиг нь хүчтэй дуудагдаж, гурван үет үгийн өргөлт нь авианы өндөр, авианы урт ба авианы чанга болон урт эгшигтэй эсэхтэй шууд холбоотой чөлөөт өргөлт болохыг баталсан. Үгийн өргөлт нь мөн эгшиг зохицох ёстой шууд холбоотой. Баоань хэл бол алтай язгуурын хэл дотор цорын ганц эгшиг зохицох ёсгүй хэл юм. Баоань хэлний өргөлт хэдийгээр үгийн эцсийн үед орших боловч, нэгдүгээр үеийн эгшгийн гээгдэх хэмжээ адилгүй. Дуун ухааны задлалыг үндэслэвэл, баоань хэлний үгийн эхний эгшгийн хүчдэлийн дараалал нь [e] > [ɛ] > [u] > [ə] > [i] > [o] болно (Дээжхүү, 2017: 47). Үүнд [ɛ] нь баоань хэлний а-г, [o] нь ө-г илэрхийлнэ..

Баоань хэлэнд үгийн эхний эгшиг гээгдсэн 46 үгийн дотор монгол бичгийн хэлний а-тай тохирох 4 (9.7%), е-тай тохирох 4 (9.7%) үг илэрч, дараа нь i эгшиг 12 (25.5%), o эгшиг 5 (10.6%), u эгшиг 17 (36.1%), ö эгшиг 1 (2.12%), ü эгшиг 6 (12.7%) үгэнд гээгджээ. Үүнд монгол бичгийн хэлний дөрөвдүгээр эгшиг о ба зургаадугаар эгшиг ö-тэй тохирох баоань хэлний [ə] 6 (13%) үгэнд илрэхэд гуравдугаар эгшигтэй тохирох [i] 12 (25.5%) үгэнд, тавдугаар, долоодугаар эгшигтэй тохирох [u] 23 үгэнд гээгдэж, 48.8%-г эзэлжээ. Тус өгүүлэлд зөвхөн үгийн язгуурыг бүртгэснийг онцолж байна. Эдгээр тоо баримт нь баоань хэлэнд монгол хэлний i, u, ü эгшигтэй тохиролцсон эгшгийн гээгдэх хэмжээ хамгийн илүү байж, а, е-тэй тохиролцсон эгшгийн гээгдэх хэмжээ тун цөөн байгааг харуулж байна. Энэ нь баоань хэлний үгийн эхний эгшгийн авианы хүчдэлийн

дуун ухааны задлалын үр дүнтэй нийцнэ. Даруй [e], [v] эгшгийн авиалах хүчдэл хамгийн өндөр байж үгийн эхэнд тэр бүр гээгдэхгүй. [o], [i] эгшгийн хүчдэл доор байдгаас үгийн эхэнд гээгдэх үзэгдэл олонтоо тохиолдоно. Үгийн эхний эгшгийн балархайшил бол тухайн эгшиг гээгдэх үндсэн шалтгаан болно. Баоань хэлний эгшиг ба монгол хэлний эгшгийн тохироог харьцуулбал доорх мэт.

Баоань	Монгол (гол тохиролцоо)	Монгол (бусад тохиролцоо)
a (153)	a (142)	i (7) э (1) u (2)
э (42)	э (10) i (12)	u (8) u (7)
e (66)	e (47)	o (2) i (4) u (4)
i (65)	i (32)	u (4) a (2) o (2) э (1)
ө (115)	o (49) o (24)	u (19) u (6) a (3) i (3)
u (57)	u (18) u (12)	o (8) i (4) э (3) ²

Баоань хэлний э нь монгол хэлний u, ü-аас гаралтай, ө эгшиг а-аас гаралтай, энэ нь үгийн эхний а u, ü эгшиг аниршиж баоань хэлэнд тус тус э, ө болсон байдаг нь, хэлний байр намаас өндөр тийш шилжсэн явцыг харуулдаг. Эдгээр аниршсан эгшиг дахин хэлний хөгжлийн явцад аажмаар авиалбарын шинжээ алдаж тодорхой бус хэлэгдэж байснаа балархайшин гээгджээ.

Үгийн эхний эгшиг гээгдэхэд зэргэлдээх гийгүүлэгчийн шинж чухал нөлөө үзүүлдэг. Үүнд хамжих болон хамжин шүргэх гийгүүлэгчдийг дурдууштай. Хамжих гийгүүлэгч авианууд өгүүлэх эрхтний саадтай тулгаран хаагдаж хийн урсгал саадыг даван гардаг. Хамжин шүргэх гийгүүлэгчийг өгүүлэхэд хамжих авианы хаалтаас гарсан хийн урсгал нь дахин өгүүлэх эрхтэнтэй шүргэж амны хөндийн булчингийн чангарлыг сулруулахын хамт зэргэлдээх эгшиг авианы уртыг богиносгож эгшгийн аниршил буюу гээгдлийг бий болгодог. Баоань хэлэнд дуугүй хамжих гийгүүлэгч h, s, s -ийн дараах эгшиг тун олон гээгддэг. Жишээлбэл, sᠭᠦᠨ(сүх), hᠭᠤ (үх), nda:nᠥᠨ (ноднин), smᠥ (сум) гэх мэт. Үүнээс гадна бас хамрын гийгүүлэгч n, m түрэлтгүй хамжих гийгүүлэгч g, c болон чичрэх гийгүүлэгч r-ийн өмнөх уруулын эгшиг гээгдэх нь нэлээд олон байдаг. Жишээлбэл, ndar- (ундаасах), mba- (умба-), na- (уна-), go (үг), cᠥᠬ (охор), ge- (ир) гэх мэт. Үүнээс үзвэл түрэлтгүй гийгүүлэгч нь түрэлтэй гийгүүлэгчээс илүү эгшигт нөлөөлөн аниршуулдаг ба голдуу өгүүлэх эрхтэнд саад учруулдаг хугацааг нэн урт болгохын чацуу эгшиг авианы уртыг богиносгодгоос болжээ.

3.2. Монгол хэл

Үгийн эхний эгшиг гээгдэхэд өргөлтийн байр чухал нөлөөтэйгөөс гадна авианы хүчдэл, эгшгийн аниршил жич тухайн эгшгийн зэргэлдээх

² Эдгээр тоо бүртгэлийг Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн Чен Най Шиён-ийн "Баоань хэлний үгс" (1986), Хасбаатар нарын "Монгол хэлний үгс" (1986), Булчулуу нарын "Зүүн ёгор хэлний үгс" (1986), Бөхөө нарын "Дуншаан хэлний үгс" (1983), Энхбатын "Дагуур хэлний үгс" (1984) эшлэв. Дараа нь гарах төрөл хэлний үгийг мөн эдгээр номоос эшлэв.

гийгүүлэгчийн шинж чанар нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Монгол хэлний үгийн эхний эгшиг гээгдсэн байдлыг доорх хэдэн төрөлд хуваан үзэж болно.

3.2.1. Эгшиг (Э) бүтцэт үе гээгдэх

Монгол хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
sga-	asu:-	asagu-	асуу-
ne	эн	ene	энэ
gətə	əgʃ	egəce	эгч
go	ug	üge	үг
de-	id-	id	ид

3.2.2. Эгшиг гийгүүлэгч (ЭГ) үеийн эхний эгшиг гээгдэх

Монгол хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
sgol-	oʃgol-	isxül-	өшиглө-
ndasə-	onda:s-	umdagas-	умдаас-
ŋɔsə	uŋgas	unggasu	унгас
ŋgo	oŋg	öngge	өнгө

3.2.3. Гийгүүлэгч эгшиг (ГЭ) бүтцэт үеийн эгшиг гээгдэх

Монгол хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
xgai	gaxai	gaxai	гахай
sga-	asga-	oasxa-	асга-
eine:də	inə:d	iniyedü	инээд
ʃda:sə	sodas	sudasu	судас
eɟə-	əʃ-	eçi-	эч-

3.2.4. Гийгүүлэгч эгшигт (ГЭ) бүхэл үе гээгдэх

Монгол хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
da:	nad	nada	над
da:ldə	xudald-	xudaldu-	худалд-
gugu	хохо:	xöxöge	хөхөө
daxgu-	onda:s-	umdagas-	умдаас-

Монгол хэл а, е, ε, э, и, о, э, у, ц, и, у зэрэг эгшигтэй. Монгол хэл ба монгол хэлний эгшигийн тохирооноос үзвэл монгол хэлний а эгшиг монгол хэлний а, и-тай, е эгшиг е ба э, и-тай, и эгшиг и ба у-тай, о эгшиг о, и-тай тохиролцож зарим үед бас а,æ, е, э-тай тохирно. У эгшиг и-аас гадна э, и-тай тохиролцож, ө эгшиг монгол хэлний о ба и-тай хамаг илүү тохирно. Ү эгшиг голдуу монгол хэлний и-тай тохирохоос гадна бас э-тай тохирдог онцлогтой. Эдгээр тохирооноос үзвэл монгол хэлний үгийн эхний о авиа нь монгол хэлэнд а, æ, е, э-аар дуудагдах, и эгшиг э, и-аар дуудагдах, ү эгшиг э-аар дуудагдах нь үгийн эхний уруулын эгшиг аниршиж уул авиалбарын шинжээ алдаад уруулын бус эгшиг

болсныг харуулж байна. Жишээлбэл, *balə-* (бол-), *sacɬə-* (соч-), *nəmo:n* (номон), *kəsəm* (хусам), *ɬzila:* (зул), *tədau* (дутуу), *təle:* (түл-), *dəle* (дөл-) гэх мэт. Үүнээс гадна монгол хэлэнд үгийн эхэнд уруулын эгшгээр дуудагдах үг бас аниршлаас болсон уруулын бус эгшгээр дуудагддаг үгтэй зэрэгцэн орших, жич, аниршсан эгшигт үг ба эгшиг гээгдсэн үг зэрэгцэн оршиж байдаг онцлогтой. Жишээлбэл, *nəjən ~ nuja:n* (ноён), *basə ~ bosə* (бөс), *pasə ~ posə* (бос), *fan ~ fon* (он), *ɬzæbləŋ ~ ɬzobbŋ* (зовлон), *sula: ~ sla:* (сул), *mula: ~ mla:* (бяцхан) гэх мэт.

Монгол хэлэнд үгийн эхний эгшиг гээгдсэн үг нийт 140 илэрчээ. Үеийн түвшнээс ажиглавал, монгол хэлэнд үгийн эхэнд эгшиг бүтцэт үе гээгдэх нь тун өндөр байж, эгшиг гээгдсэн бүх үгийн 55(39.2%)-г эзэлж байна. Харин эгшиг гийгүүлэгчээр төгссөн үеийн эгшиг гээгдсэн үг 18 (12.8%), гийгүүлэгч эгшиг гээгдсэн үг 51 (36.4%), гийгүүлэгч эгшигт бүхэл үе гээгдсэн үг 6 (4.28%) бий. Энэ нь монгол хэлний эгшгийн гээгдэл голдуу эгшгээр эхэлсэн үгтэй холбогдохыг харуулна. Харин баоань хэлэнд эгшиг бүтцэт үе гээгдсэн үг 32.6%-г эзэлж, гийгүүлэгчээр эхэлсэн үгийн эгшиг гээгдэх нь 43.4%-г эзэлж, үгийн эхэнд хоёр гийгүүлэгчийн дундах эгшиг гээгдэх нь нэн илүү байдаг.

Монгол хэлний үгийн өргөлт хэдийгээр эцсийн үед байдаг боловч үгийн эхний эгшиг бүхэн гээгддэггүй. Энэ нь эгшгийн авианы урт, авианы өндөр жич авианы чангатай холбоотой. Хан Гүе Жиүн (2013) монгол хэлний эгшигт дуун ухааны задлал хийж эгшгийн авианы урт, хүчдэл ба авианы өндрийн тухай ихээс бага тийш доорх мэт жагсаажээ.

Авианы хүчдэл : $o > e > ɔ > \varepsilon > a > u > ɯ > u > y > \varepsilon > i$

Авианы урт : $o > e > \varepsilon > ɔ > a > u > ɯ > i > \varepsilon > ɯ > y$

Авианы өндөр : $o > e > ɔ > \varepsilon > i > \varepsilon > ɯ > u > ɯ > y > a$

Үүнд ε (g, k, x, г-ийн хойно) бол e-ийн хувилбар, ε (ɬ, tɛ, ɛ, j-ийн хойно) бол i-ийн хувилбар, ε (ɣ, ŋ-ийн өмнө), u (x-ийн хойно) бол o-ийн хувилбар, y (ɬ, tɛ, ɛ, j-ийн хойно) бол u-ийн хувилбар мөн. Дээрх “жагсаалт”-аас үзвэл монгол хэлний авианы хүчдэл хамгийн сул нь ε , i, хамгийн чанга нь o, e, a, зэрэг эгшиг болно. Эдгээр эгшгийн авианы урт ба авианы өндөр нь мөн хамгийн их байдаг. Үүнээс монгол хэлэнд монгол хэлний o, a-тай тохирсон үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл тун цөөн, авианы хүчдэл доор байгаа ε (i-ийн хувилбар), i, u зэрэг эгшиг үгийн эхэнд гээгдэх нь илүү олон байдаг. “Монгол хэл ба монгол хэлэнд e эгшиг биеэ дааж үе бүтээдэггүй зөвхөн гийгүүлэгчтэй хамт илэрдэг. Үүнээс гадна o эгшиг мөн үе бүтээх үзэгдэл тун цөөн тохиолдоно (Цэнгэлдэй, 1991: 127). Монгол хэлэнд өргөлтгүй үеийн “a” эгшгийн дуудлага хувирч зэргэлдээх гийгүүлэгчийнхээ хэлэгдэх байртай ойролцоо уйтан эгшиг болсон нь үгийн эхний a эгшгийн гээгдэх үзэгдлийг их болгожээ. Ер нь эгшгийн гээгдэл эгшиг > эгшгийн аниршил > эгшгийн гээгдэл гэх явцыг дамждаг. Монгол хэлэнд үгийн эхний эгшиг гээгдсэн 140 үг дотор монгол бичгийн хэлний a-тай тохирох 23 (16.4%) үг, e-тай тохирох 32(22.8%), i-тай тохирох 18 (12.8%), o-тай тохирох 13 (9.28%), u-тай тохирох 22 (15.7%), ε -тай тохирох 14 (10%), \ddot{u} -тай тохирох 18 (12.8%) үг илэрчээ. Эдгээр тоо баримтаас үзэхэд монгол хэлэнд монгол хэлний i, u, \ddot{u} эгшигтэй тохирсон эгшгийн гээгдэх хэмжээ хамгийн олон, o эгшигтэй тохиролцсон үгийн гээгдэх хэмжээ хамгийн цөөн байдаг.

Монгол хэлний эгшиг гээгдэлд зэргэлдээх гийгүүлэгч зохих нөлөө үзүүлжээ. Хамрын *n*, *ŋ*, *m* -гийгүүлэгчийн өмнөх эгшиг амархан гээгддэг. Жишээлбэл, *ndasə-* (умдаас-), *nde:* (энд), *ndəgz* (өндөг), *ŋgʊsə* (унгас), *ŋgə* (өнгө), *mosən* (өмс-), *moeə-* (унш-), *mugən* (эмгэн) гэх мэт. Жишээлбэл, хамрын *n* гийгүүлэгч өмнөх эгшгээ хамаршуулдгаас болж *n*-аар төгссөн үеийн эгшгийг дуудахад амны нээлт нь *n* үгүй эгшгээс уйтан байдаг. Энэ нь *n* гийгүүлэгч өмнөх эгшгийнхээ хэлэгдэх байрыг өөрчилснөөс болжээ. Дараа нь хамжих гийгүүлэгч чухал нөлөө үзүүлжээ. Түрэлтгүй хамжих гийгүүлэгч *d*, *g*, *ɣ*-ийн өмнөх эгшиг, түрэлтгүй шүргэх гийгүүлэгч *s*, *ɕ*, *ʃ*, *x*-ийн дараах эгшиг амархан гээгддэг. Жишээлбэл, *ʃda* :*sə* (утас), *ʃdə* (шүд), *ɕine:də* (инээд), *ɕdza:* (ачаа), *xgai* (гахай), *xgə* (эх), *sgor* (сохор), *scal* (сахал) гэх мэт. Дуугүй хамжих ба түрэлтгүй шүргэх гийгүүлэгчийг дуудахад хийн урсгал харш саадыг нэвтлэн гарахын дагуу хойнох эгшгийнхээ авианы уртыг богиносгодогтой холбоотой. Үүнээс гадна чичрэх гийгүүлэгч *ɣ*-ийн өмнөх эгшиг гээгдэх үзэгдэл түгээмэл илэрнэ. Жишээлбэл, *rgo:dʒə* (үргээсү), *rgon* (өргөн), *ɣme:n* (өрөм), *ɣdem* (эрдэм) гэх мэт.

3.3. Зүүн ёгор хэл

Зүүн ёгор хэлэнд эр чанга эгшиг *a*, *ɔ*, *u*, эм хөндий эгшиг *e*, *o*, *ø*, *ɯ*, саармаг эгшиг *i*, *ə*, *y* зэрэг бий. Зүүн ёгор хэл болон монгол хэлний эгшгийн тохироог шинжвэл, *a* нь монгол хэлний *a*-тай, *e* нь монгол хэлний *e*-ээс гадна *ü*, *ö*-тэй, *ə* нь *i*-аас гадна *u*, *ü*, *a*, *e*-тай, *i* голдуу *i*-тай, *ɔ* нь *o*, *u*-тай, *o* нь *ö*, *ü*-тай, *u* нь *u*-аас гадна *o*, *a*-тай, *ɯ* нь *ü*, *ö*-тай, *ø* нь *ö*, *ü*-тай тус тус тохирдог. Үүнд, ёгор хэлний *e* эгшиг монгол хэлний *ü*, *ö*-тай тохирох, жич *ə* эгшиг монгол хэлний *u*, *a*, *e*-тай тохирох нь ёгор хэлний үгийн эхний эгшгийн аниршлыг харуулж байна. Жишээлбэл, *pes* (бөс), *temen* (түмэн), *peɕeŋ* (бөжин), *ʃelen* (шөлөн), *əgeʃə* (эгч), *kəseɣ* (хэсэг), *səтэн* (суман), *qəsəɣaŋ* (хусран), *bəjan* (баян), *pəsa* (бас) гэх мэт. Монгол бичгийн хэлний уужим эгшиг *a* ба уруулын эгшиг *u*, *ö*, *ü*-г ёгор хэлэнд *e*, *ə*-аар хэлдэг нь эдгээр эгшгийн авианы хүчдэл сул болж, уруулших шинжээ алдаад аниршиж эхэлснийг харуулж байна. Үүнээс болж *bəjan* (баян), *pəsa* (бас) зэрэг үгэнд эр чанга болон эм хөндий эгшиг холилдон орсон үзэгдэл бий болсон бөгөөд *qəsəɣaŋ* (хусран), *səтэн* (суман), *nəтэн* (номин) зэрэг үгэнд аниршсан эгшгийн тойронд эгшгийн зохицол дахин шинээр бий болсон байна. Өргөлтөөс болсон үгийн эхний эгшиг *ə*-ийн аниршил хамгийн тод илэрдэг онцлогтой. Иймэрхүү аниршсан эгшиг дуугүй, тодорхой бус, хүчдэл сул зэрэг онцлогоор ялгардаг (Булчулуу, Залсан. 1991: 74). Ингэж үгийн эхэнд өргөлтөөс болж аниршсан эгшиг ярианы орчинд авиалбарын шинжээ алдаад аажмаар гээгдсэн байна. Зүүн ёгор хэлний эгшгийн гээгдсэн байдлыг хураангуйлбал доорх мэт.

3.3.1. Эгшгээр бүтсэн үеийн эгшиг гээгдэх

Зүүн ёгор хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
<i>vesən</i>	<i>ows</i>	<i>ebeṣü</i>	өвс
<i>ber</i>	<i>əwəɣ</i>	<i>eber</i>	өвөр
<i>ni:-</i>	<i>inə:-</i>	<i>iniye-</i>	инээ-
<i>nu:-</i>	<i>önə-</i>	<i>ono-</i>	оно-

la:n	ɔla:n	ulagan	улаан
ʃfogdor	ɔʃfogdor	öcögedür	өчигдөр
ni:n	unə:n	üniyen	үнэн

3.3.2. Эгшиг гийгүүлэгч үеийн эгшиг гээгдэх

Зүүн ёгор хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
ndagar	andgar	andagar	андгар
ski:	isgi:	isgei	эсгий
mba-	ɔmba-	umba-	умба-
ŋgwa:sən	ɔŋgas	unggasu	унгасан

3.3.3. Гийгүүлэгч эгшигт үгийн эгшиг гээгдэх

Зүүн ёгор хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
hke	эх	ehe	эх
hsun	us	üsü	үс
sda:sən	sodas	sudasu	судас
ʃdən	ʃud	sidü	шүд
ʃflu:	ʃfɔlɔ:	čilagu	чулуу

Цуглуулсан хэрэглэгдэхүүнийг үндэс болговол, зүүн ёгор хэлэнд үгийн эхний эгшиг гээгдсэн үг нийт 91 илэрчээ. Үүнд, эгшиг бүтцэт үе гээгдсэн үг 30 (32.9%), эгшиг гийгүүлэгчээр бүтсэн үеийн эгшиг гээгдсэн үг 9 (9.8%), гийгүүлэгч эгшгээр бүтсэн үгийн эгшиг гээгдсэн үг 52 (57.1%) илэрч, харин гийгүүлэгч эгшигт бүхэл үе гээгдсэн үг илрээгүй. Эдгээр тоо баримт нь зүүн ёгор хэлэнд гийгүүлэгч эгшгээр бүтсэн үеийн эгшиг гээгдсэн тохиолдол хамгийн их хувийг илтгэнэ.

Зүүн ёгор хэлний үгийн эхний эгшгийн гээгдэлд нөлөөлөх зэргэлдээх гийгүүлэгчид голдуу хамрын гийгүүлэгч n, ŋ болон дуугүй шүргэх гийгүүлэгч s, ʃ, h зэрэг орно. Үүнд n, ŋ нь үгийн эхний эгшгийн хойно тохиолдож, s, ʃ, h нь эгшгийн өмнө тохиолдоно. Жишээлбэл, nda- (унд-), ŋgwa:sən (унгасан), sda:sən (судас), ʃra (шар), sdən (шүдэн), hɔɔr (охор), hgor (үхэр), hta:(отго) гэх мэт. Үүнээс гадна хамжин шүргэх гийгүүлэгч ʃ, ɕз-ийн хойнох эгшиг ч гээгддэг. Жишээлбэл, ʃge (эцэг), ʃna (чана), ʃkən (чихин) гэх мэт. Зүүн ёгор хэлний эдгээр эгшгийн гээгдэл бол тухайн эгшиг өмнөх дуугүй гийгүүлэгчтэйгээ ижилссэнээс шалтгаалжээ (Булчулуу, Залсан, 1991: 142). Зүүн ёгор хэлний өргөлтийг нарийн шинжилбэл тогтмол нэг үе дээр байхгүй, харин үгийн аль ч үед тохиолдож болдог чөлөөт өргөлт болно. Тус хэлний өргөлтийн дараалал нь хамгийн тэргүүнд урт эгшиг, дараа нь э-ээс бусад богино эгшиг буюу хос эгшиг, хамгийн сүүлд э эгшиг дээр байдаг (Булчулуу, 1991: 142). Энэ нь үгийн эхэнд балархайшин аниршсан эгшгийг ихэнхдээ э-аар хэлэхээс болжээ. Хасхүү (2014: 142) зүүн ёгор хэлний үгийн эхний богино эгшигт дууны задлал хийгээд уйтан эгшгийн хүчдэл нь харьцангуй сул, агуу эгшгийн хүчдэл харьцангуй чанга

байдаг гэх дүгнэлтийг гаргасан бөгөөд эгшгийн хүчдэлийг чангаас сул тийш [ø] > [o] > [ɔ] > [ɐ] > [ɯ] > [ʊ] > [i] > [ɛ] > [y] > [u] гэх дарааллаар жагсаажээ. Үүнд [y], [ɛ] нь i-ийн хувилбар, [ɐ] нь e-ийн хувилбар байж, [ɔ] нь монгол хэлний дөрөвдүгээр эгшиг [o]-той, [ø] нь зургаадугаар эгшигтэй, [u] нь тавдугаар эгшигтэй тус тус тохирч буй. Үүнээс үзэхэд зүүн ёгор хэлний [a], [o], [ɔ]-ийн хүчдэл хамгийн өндөр, [u], [i] эгшгийн хүчдэл хамгийн бага байдаг. Иймээс [u], [i] эгшиг үгийн эхэнд хамгийн илүү гээгдэж, [a], [o] эгшиг гээгдэх үзэгдэл цөөн үгэнд илэрчээ.

3.4. Дуншаан хэл

Дуншаан хэл а, ш, э, i, о, u зэрэг эгшигтэй бөгөөд о нь монгол хэлний дөрөвдүгээр ба зургаадугаар эгшигтэй, u нь монгол хэлний тавдугаар ба долоодугаар эгшигтэй тохирно. ш бол үгийн эхний q, ʏ, t гийгүүлэгчийн хойнох i, a-тай тохирно. Тус хэлэнд үгийн эхний эгшиг гээгдсэн үг нийт 9, а эгшиг 4, э эгшиг 2, о, u, ü эгшиг тус тус нэг үгэнд илэрчээ.

Дуншаан хэл	Монгол ярианы хэл	Монгол бичгийн хэл	Утга
ika	ajag	ayaga	аяга
məliə	omon	emüne	өмнө
misi-	oms-	emüs-	өмс
pau-	ono-	önö-	оно-
məduŋ	omden	ömödü	өмд
sdasuŋ	sodas	sudasu	судас
sdzi	saŋ-	saču-	сац-

Дуншаан хэлний өргөлт олонхдоо үгийн эцсийн үед байж эгшгийн зохицол үлдэгдлийн шинжтэй оршдог. Үүнд тус хэлэнд үгийн эхний эгшиг гээгдэх нь тун цөөн байж, олонхдоо m гийгүүлэгчийн өмнөх эгшиг болон sd, sdz хоёр гийгүүлэгчийн хоорондох эгшиг гээгддэг. Дуншаан хэлний үгийн эхний эгшгийн дараа ямар эгшиг ордог тухай бүртгэн үзсэн (Бөхөө, 1986: 78)-ийг үндэслэвэл адил эгшгийн хоёр үед илрэх хэмжээ бусад эгшгээс мэдэгдэм өндөр байдаг. Энэ нь үгийн эхэнд эгшиг гээгдэх үзэгдэл цөөрсний шалтгаан болно. Үүнээс гадна дуншаан хэлэнд холбоо үгийн хоёр дахь үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл түгээмэл оршино. Энэ бол хэл ярианы орчинд тухайн үгсийн холбоосыг түргэн ярихаас болж хоёрдугаар үеийн эгшиг гээгдсэн үзэгдэл мөн. Жишээлбэл, tawi ka (таван аяга), guru du (гурван өдөр), asuŋ sula (адуусун усла) зэрэг үгэнд орсон ika (аяга), du (өдөр), usu (ус)-ыг тус тус ингэж дууддаг.

Үүнээс гадна дагуур хэлэнд үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл зөвхөн поо-(онох) гэх үгэнд илэрчээ. Энэ нь дагуур хэлний өргөлт тогтмол үгийн нэгдүгээр үед байгаатай холбоотой. Тус хэлэнд үгийн нэгдүгээр үед орших хүчлэх өргөлт байхаар барахгүй бас үгийн эцэст орших эгшиглэх өргөлттэй байдаг. Үгийн эхэнд богино эгшиг болон урт эгшгийн аль нь илэрсэн ч тод дуудагдана. Үүнээс болж үгийн эхний үеийн төвөнхийн шүргэх гийгүүлэгчтэй тохирох “x”, жич дараах эгшиг нь уул хэвээр хадгалагдаж буй. Дагуур хэлний эгшгийн зохицол ч нэлээд чанга байдаг.

Монгол төрөл хэлэнд үгийн эхний үеийн эгшиг гээгдсэн нэлээд үгэнд дундад эртний монгол хэлний төвөнхийн шүргэх гийгүүлэгч хадгалагдаж байжээ.

дагуур ³ монгол хэл	баоань	монгор	зүүн ёгор	дуншаан	
os	sū/sa	ʂdzu	qusun	usu	ус
onə-	xonə-	unə-	hunə-	unu-	уна-
ʃiʃ-	ɕziə-	ɕdʒee-	hidʒe-	ʂudʒə-	ич-
хонҗə-	hunҗə-	ŋcosə-	honҗə-	hunҗu-	унга-
xwakəɣ	gor	xɣuar	xogor	oqo	охор
хонпраа-	mba-	xumba-	umba-	unba-	умба-
xulaan	fulaŋ	fulaan	laan	fulaŋ	улаан
xasoo-	ascə-	sga-	sura-	asa-	асуу-
əɣ	aamə	aam	hke	ana	эх
xəur	uer	ver	ewer	xo	үүр
ati-	ateiaŋ	ɕdʒaa-	aʃə-	atʂu-	ачаа
want-	təra-	ntəraa-	nda-	huntura-	унт-
xuns-	olos-	losə-	tur-	oliəsi-	өлс-
xudʒuur	udʒir	ɕdʒiuur	dʒyу	udʒu	үзүүр
udif udur	gudəɣ	teigudur	ʃyɣdu	fudʒuku	өчигдөр
xinəədəm	eineduŋ	ʂdzu	həsun	usun	үс

Монгол төрөл хэлэнд үгийн эхний эгшиг гээгдсэн үгс нь анхандаа төвөнхийн шүргэх гийгүүлэгчтэй байсныг эдгээр жишээнээс мэдэж болно. Жишээлбэл: qusun (зүүн ёгор: ус), хонə- (баоань: уна-), hunə-(зүүн ёгор: уну-), хасoo- (дагуур: асуу-) , hke (зүүн ёгор: эх), fulaan (монгор: улаан), huntura- (дуншаан: унтах), хuns- (дагуур: өлс-), fudʒuku (дуншаан: өчигдөр), хumba- (монгор: умба-) гэх мэт. Үүнд, дагуур хэлэнд үгийн эхний эгшигийн өмнөх төвөнхийн шүргэх гийгүүлэгчтэй тохирох “х” анхны хэлбэрээрээ хадгалагдаж буй. Энэ нь тус хэлний өргөлт үгийн эхэнд тогтмол оршиж, эгшиг гээгддэггүй онцлогтой шууд холбоотой. Харин баоань хэлэнд үгийн эхний эгшиг болон түүний өмнөх шүргэх гийгүүлэгч гээгдсэн нь нийтлэг бөгөөд дуншаан хэл, зүүн ёгор хэл болон монгор хэлэнд эгшиг гээгдэх хэмжээ нь харьцангуй цөөн байна. Жишээлбэл, баоань хэлэнд sū (ус), ɕziə- (ич-), gor (охор), uer (эвэр), gudəɣ (өчигдөр), suŋ (үс) гэх мэт. Үүнээс гадна баоань хэлэнд бүлэг үгийн эхний эгшиг гээгдсэн ба эс гээгдсэн хоёр зүйлийн хэлбэр зэрэгцэн оршиж буй. Жишээлбэл: fgor ~ gor (үхэр), fgo ~ go (их), da ~ fda (уут), fgu- ~ gu- (үх-) гэх мэт. Зүүн ёгор хэлэнд мөн иймэрхүү байдал илэрнэ. Жишээлбэл: həɣte~hrte (эрт), hhojan ~ hjan ~ jan (ачаа), həjeve ~ hqeqe (хазгай), hejeke ~ qenke (эцэнхий), hkor ~ gor (үхэр) гэх мэт. Нэн ялангуяа 1980 оны зүүн ёгор хэлний шинжилгээний материал болон ойрын жил

³ Эдгээр үгийг Үндэстний хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн Бөхөө, Лю Жаошүнгийн “Баоань хэлний товч ойллого” (1982), Лю Жаошүнгийн “Дуншаан хэлний товч ойллого” (1981), Зуунастын “Монгор хэлний товч ойллого” (1981), “Зүүн ёгор хэлний товч ойллого” (1981), Зуун Сүүцүний “Дагуур хэлний товч ойллого” (1981)-аас эшлэв.

шинээр цуглуулсан материалыг харьцуулж үзвэл үгийн эхний h авиа гээгдэх үзэгдэл нэлээд олон бий. Жишээлбэл: hcenɛ:ɣ ~ cɛnɛ:ɣ (эр нөхөр), hurtu ~ ʊɣtʰə (урт), hta: ~ tʰə: (утаа), hidʒe ~ ʃeʃ (ичих), hsəra- ~ esrɛ- (асар-) (Алтансувд, 2023: 136). Эдгээр жишээнээс үзвэл, монгол төрөл хэлэнд өргөлтөөс шалтгаалж дундад эртний монгол хэлний төвөнхийн шүргэх гийгүүлэгч “h” бүхий бүлэг үгийн эхний эгшиг урьдаар балархайшин гээгдэж, дараа нь энэхүү шүргэх гийгүүлэгч гээгджээ. Үүнд, баоань хэл болон зүүн ёгор хэлэнд үгийн эхэнд эгшигтэй, эгшиггүй хоёр зүйлийн хэлбэр оршиж байгаа нь үгийн эхний эгшигийн гээгдэх явцыг харуулж буй. Иймээс үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл монгол хэл, баоань хэл ба зүүн ёгор хэлэнд тун идэвхтэй явагдаж, дуншаан хэл болон монгол хэлэнд тун цөөн илэрдэг. Нэн ялангуяа дагуур хэлний үгийн өргөлт тогтмол нэгдүгээр үед байдгаас үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл бараг илрэхгүй.

Үүнээс гадна гийгүүлэгч эгшигт бүхэл үе гээгдсэн байдлыг авч үзвэл, баоань хэлэнд хамгийн идэвхтэй байдаг бол дараа нь монгол хэл орно. Зүүн ёгор хэл ба дуншаан хэл эртний монгол хэлний онцлогийг илүү хадгалдаг тул үгийн эхний эгшигийн гээгдэл нь төдий идэвхтэй биш байдаг. Нэн ялангуяа дагуур хэлэнд үгийн эхний эгшиг бараг гээгдэхгүй.

баоань	монгол	ёгор	дуншаан	дагуур	монгол
lɔŋ	slɔŋɔ	sɔlɔŋɔ		ʃe:ru:	солонго
ta:	nta	ndara-	huntura-	want	унт-
ʒɡudə	teigudur	ʃɔɡɔdɔr	fudʒuɣu	uʃi:kən	өчигдөр
cɔr	xɔɣɔr	hcɔr	oqo	xwakər	охор
dalda	da:ldə	ɡudaldən	ɡudandu	dullw	худалд-
ge	dəge	hətɛge		ədəy	эдгэ-

4. Нийлмэл гийгүүлэгчийн бүрэлдэл

Монгол төрөл хэлэнд гийгүүлэгч эгшигт үеэр эхэлсэн бүлэг үгийн эгшиг гээгдэж нийлмэл гийгүүлэгчийг бий болгожээ. Энэ нь баоань хэл, монгол хэл, дуншаан хэл ба зүүн ёгор хэлний өргөлт үгийн эцсийн үе дээр байдгаас шалтгаалжээ.

4.2. Тухайн эгшигийн хойнох гийгүүлэгч ба дараах үеийн гийгүүлэгчийн нийлэмж

Үгийн эхний эгшиг гээгдэж түүний хойно дэвсгэрлэж орсон гийгүүлэгч ба хоёрдугаар үеийн гийгүүлэгч нийлэн бүтсэн нийлмэл гийгүүлэгч голдуу монгол хэл ба зүүн ёгор хэлэнд илэрнэ. Түүнийг төрөл зүйлээр нь ангилбал: 1) n+ d, dz 2) ŋ + g, k, ɣ 3) r + d, g, dz 4) s + r, q, ɣ 5) m+b зэрэг гийгүүлэгч үе буй. Үүнд, n, ŋ гийгүүлэгч эхтэй нийлмэл гийгүүлэгч зонхилно.

Монгол хэл :

ndəca (андгай), ndasə- (умдаас-), nda:- (унт-), ndzæsə (анжис)
ŋge (энгэр), ŋguteəɣ (онгоц), ŋguro:- (өнхөр)
sga- (асуу-), sga- (асга-), sɣol (өшиглө-), sɣi: (эсгий)
rdem (эрдэм), rɣon (өргөн)

Ёгор хэл :

ndacar (андгай), nda- (унт-), ndara- (ундар-), nda:n (ундаа)
ŋɣarɣaɣ (янгирцаг), ŋɣwa:sən (онгосон)
mba- (умба-)

Эдгээр нийлмэл гийгүүлэгч хэлэгдэх байрын хувьд ойролцоо шинжтэй байна. n, d, dz нь хэлний урдуур хамжих болон хамжин шүргэх гийгүүлэгч, харин ŋ, g, k, ɣ нь хэлний угийн хамжих гийгүүлэгч, m, b хоёр уруулын гийгүүлэгч юм. Иймэрхүү гийгүүлэгчийн хэлэгдэх байрын ижил шинж нь нийлмэл гийгүүлэгч бүрэлдэхэд дөхөм болжээ.

4.2 Тухайн эгшгийн өмнөх гийгүүлэгч ба дараах үеийн гийгүүлэгчийн нийлэмж

Үгийн эхний эгшиг гээгдсэний дараа өмнөх гийгүүлэгч нь дараах үеийн гийгүүлэгчтэйгээ холбогдон нийлмэл гийгүүлэгч бүрэлдүүлэх үзэгдэл баоань хэл, монгол хэл, зүүн ёгор хэл ба дуншаан хэлэнд түгээмэл илэрнэ.

Баоань хэл:

ʂ: ʂdasəŋ (утас), ʂdəŋ (шүд), ʂdzal (сацал), ʂdze- (ич-), ʂda (шат)
h: hɣu- (үх-), hta: (ут), hda (уут), hɔl (огтол-)
ʕ: ʕdzudə (уржигдар), ʕdzinə (уржнан)

Монгол хэл:

ʂ: ʂdergз (үтрэм), ʂgз (их), ʂda:sə (утас), ʂdə (шүд), ʂdəgu (өтөх), ʂdogo:n
e: eɔza:- (ачаа), eɔze:- (ич-), eɔzun (охин), eɔzɣa:- (учир-), eɔzu:r (язгуур)
x: xgə (эх-), xger (эхэр)

Зүүн ёгор хэл:

h: hsəra- (асар-), hrɣa (арч-), hdzan (ачаа), hfəra (ачир), hke (эх),
hfəŋki (эцэнхий), hrɣ:r (ёроол), hfɣ:r (ичгүүр), hɣɣ (охор), hta: (утаа),
hfɣr (учир), hkon (охин), hɣor (үхэр), hɣn (сүү), hɣn (үс)
s: sqar- (исгэр-), ski: (эсгий), sda:sən (судас)
ʃ: ʃeɣe (ишиг), ʃdən (шүд), ʃda (чад-), ʃkən (эхэн), ʃkəɣ (ихэр), ʃra (шар)
tʃ: tʃge (эцэг), tʃlu: (чулуу)

Дуншаан хэл:

s: sdasɣ (судас), sdzi (сац-)

Эдгээр нийлмэл гийгүүлэгч гол төлөв дундад эртний монгол хэлний төвөнхийн шүргэх гийгүүлэгч нь хойнох эгшгээ гээхийг дагалдан хоёрдугаар үеийн хамжих гийгүүлэгч буюу хамжин шүргэх гийгүүлэгчтэй уялдан буй болжээ. Дундад эртний монгол хэлний төвөнхийн шүргэх гийгүүлэгч монгол төрөл хэлэнд адил бус гийгүүлэгч болон хувирдаг. Баоань хэлд h, ʂ, ʕ, монгол хэлэнд x, e, ʂ, s, зүүн ёгор хэлэнд h, s, ʃ, дуншаан хэлэнд h, x, e, ʂ, дагуур хэлэнд

х-ээр илэрдэг. Эдгээр төвөнхийн гийгүүлэгч дараах гийгүүлэгчтэйгээ нэгдэж нийлмэл гийгүүлэгч болоход дундах эгшиг гээгдэхээс гадна хойнох гийгүүлэгчийн шинж чухал нөлөө үзүүлжээ. Даруй \int , ϵ олонхдоо i , u эгшгийн өмнө тохиолдож, дараах үед нь хамжих гийгүүлэгч d ба хамжин шүргэх \mathcal{d} илрэхэд эгшиг гээгдэн нийлмэл гийгүүлэгч $\int d$ (баоань, монгор), $\int \mathcal{d}$ (баоань), $\epsilon \mathcal{d}$ (монгор)-г бий болгодог. Зүүн ёгор хэлэнд \int голдуу i эгшгийн өмнө илэрч, түүний хойно хамжих гийгүүлэгч k илрэхэд дундах эгшиг гээгдэн нийлмэл гийгүүлэгч $\int k$ -г бүрэлдүүлнэ. h бол баоань хэлэнд илрэх төвөнхийн шүргэх гийгүүлэгч бөгөөд хоёрдугаар үед нь хамжих гийгүүлэгч g , k , t , d илрэхэд эгшиг гээгдэж, нийлмэл гийгүүлэгч hg hk ht hd -г бүрэлдүүлнэ. Хоёрдугаар гийгүүлэгч нь хамжин шүргэх \mathcal{d} бол төвөнхийн шүргэх гийгүүлэгч нь \int болон хувирч $\int \mathcal{d}$ -ийн нийлмэлийг бүрэлдүүлнэ. h бол зүүн ёгор хэлний төвөнхийн шүргэх гийгүүлэгчийн гол хэлбэр болох бөгөөд түүний дараа илрэх a , e , i , o , u , \ddot{o} , \ddot{u} зэрэг эгшиг болгон нь гээгдэх үзэгдэл бий. Эдгээр эгшгийн дараах гийгүүлэгчийг шинжилбэл, хамжин шүргэх гийгүүлэгч \mathcal{d} , \int , хамжих гийгүүлэгч g , k , t , d , s жич, чичрэх гийгүүлэгч g байж болно.

Монгол төрөл хэлэнд өргөлтөөс болж төвөнхийн шүргэх гийгүүлэгчийн дараах эгшиг гээгдэж, үгийн эхэнд нийлмэл гийгүүлэгч илэрч байснаа хэлний хөгжлийн явцад дахин төвөнхийн шүргэх гийгүүлэгч гээгджээ. Энэ нь эдгээр хэлэнд тэгш бусаар явагдсан байна. Монгол төрөл хэлний нийлмэл гийгүүлэгчийн уялдах онцлогийн тухай Хасбагана (2014: 208)-д эгшгийн дараах түрэлтгүй хамжих гийгүүлэгч ба хамжин шүргэх гийгүүлэгч, хамрын гийгүүлэгч зэрэг чухал нөлөө үзүүлнэ гэсэн байна. Ерөнхийдөө монгол төрөл хэлэнд нийлмэл гийгүүлэгч бий болоход дундад эртний монгол хэлний төвөнхийн шүргэх гийгүүлэгчийн дараа голдуу уйтан эгшиг i , u илэрч, хойно нь d (d , t) ба g (g , k) төрлийн хамжих гийгүүлэгч, жич \mathcal{d} (\mathcal{d} , \mathcal{d} , \int) төрлийн хамжин шүргэх гийгүүлэгч илрэхэд эдгээр уйтан эгшиг гээгдэж нийлмэл гийгүүлэгчийг бий болгодог.

Үүнээс гадна монгол төрөл хэлэнд үгийн эхэнд орших s , \int зэрэг гийгүүлэгчийн дараа хамжих гийгүүлэгч d , хамжин шүргэх гийгүүлэгч \mathcal{d} , \int илэрвэл мөн нийлмэл эгшиг бүрэлдэнэ. Жишээлбэл, дуншаан хэлний $s\text{dasu}\eta$ (судас), sdzi (сац-), зүүн ёгор хэлний $\text{sda:s}\ddot{a}\text{n}$ (судас), $\int d\ddot{a}\text{n}$ (шүд), $\int d\ddot{a}$ (чад-) гэх мэт. Монгол төрөл хэлэнд бас бүхэл үе гээгдэх үзэгдэл оршдог. Жишээлбэл, баоань хэл: dalda - (худалд-), ge:- (итгэ-), naqa (шанага), $\text{l}\ddot{o}\eta$ (солонго), la:- (уйл-), mande- (нумд-), ta:- (унт-), монгор хэл: daxgu (ундаасах), $\text{da:ld}\ddot{a}$ (худалд-), $\text{gog}\ddot{o}:\eta$ (өнхрөн), дуншаан хэл: guala (хоёулаа), $\text{gi}\ddot{e}\text{ru-}$ (өнгөр-) гэх мэт.


5. Монгол хэлний үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл



Монгол сурвалж бичгийг шүүж үзвэл одоогийн гийгүүлэгчээр эхэлсэн цөөн хэдэн үгийн өмнө тохирсон эгшиг байжээ. Хэлний хөгжлийн явцад эдгээр үгийн эхний эгшиг гээгдэж гийгүүлэгчээр эхэлсэн үг болон хувирсан байна.



5.1. Монгол сурвалж бичиг дэх үгийн эхний эгшиг гээгдэл



ХIII-XVIII зууны сурвалж бичиг “Монголын нууц товчоон”, “Уйгуржин үсгийн сурвалж бичиг” (Төмөртоого, Д. 2006)⁴, “Мукадимат Ал-Адаб монгол хэлний толь” (Хас-Эрдэнэ, 2020), “Алтан товч”⁵, “Гэсэрийн бүрэн бичиг”⁶ (2002), “Хөх судар” (1979), “Таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг” (1957)⁷ зэрэгт одоо үеийн монгол бичгийн хэлний гийгүүлэгчээр эхэлсэн үгийн өмнө зохих эгшиг орсон үзэгдэл илэрнэ.



“Монголын нууц товчоон”-д ‘умартах’ хэмээх үг 兀馬⁸ 兒塔 (умарта)⁸ хэлбэрээр 9 удаа илэрч, 忘了着 (мартах) гэх утгаар мөн илэрдэг. Үүнээс гадна XIV зууны уйгаржин үсгийн сурвалж бичигт мөн “умарт” хэлбэрээр 11 удаа илэрсэн бол “мартах” хэлбэр илэрдэггүй. XVII-XIX зууны сурвалж бичигт “умартах” гэдэг үгээс эхний /u/ эгшиг гээгдэж буй болсон “мартах” хэлбэр тохиолдох боловч “умартах” нь харьцангуй олон хэрэглэгдэж байжээ. “Алтан товч”-д “умартах” 4 удаа, “мартах” нь “бүү март”, “үл мартах” гэж 2 удаа илэрдэг. “Таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг” (1957)-д “умартах” 4 удаа, “мартах” 2 удаа илэрсэн бөгөөд “умартамтгай”-ийн утгыг “бас мартамтгай хэмээмүй (1.562.2)” хэмээн тайлбарлаж буй. “Хөх судар”-т “умартах” 14 удаа илэрч, “мартах” 1 удаа илэрчээ. Эдгээр жишээнээс үзвэл, XIII-XV зууны дундад эртний монгол хэлэнд зөвхөн “умартах” хэлбэр хэрэглэгдэж байснаа XVII зуунаас эхлэн “мартах” илэрч, “мартах” ба “умартах” хамтаар хэрэглэгдэх болжээ. Улмаар XIX зуун хүртэл “умартах” идэвхтэй хэрэглэгдэж байснаа XX зуун болоход “мартах” хэлбэрээр бүрмөсөн тогтжээ.



Дундад эртний монгол хэлэнд “өмхий” хэмээх үг үгийн эхэнд төвөнхийн шүргэх h гийгүүлэгчтэй байжээ. “Монголын нууц товчоон”-д 忽蔑該 (хөмхий)⁹-өөр 2 удаа илэрнэ. Уйгаржин монгол бичигт дундад эртний монгол хэлний төвөнхийн шүргэх h авиаг тэмдэглэх нь хятад үсэг болон дөрвөлжин үсгийнх шиг тодорхой биш байдаг. Гэвч “Мукадимат Ал-Адаб монгол хэлний толь бичиг”-т ‘hümekei’-ээр, “Таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг”-т “” (1.1403.4) хэлбэрээр илэрч, “санаа нарийн, асвар бус хүн” гэх утгаар хэрэглэгджээ. Ер нь тус тольд тухайн үеийн нутгийн аялгууны үг цөөнгүй байдаг. Жишээлбэл:



 (eyi):  (1.1191.3)

 (merser):  (3.3491.4)

 (ogo):  (3.3480.3)

 (dai):  (3.3457.1)

 (gasan):  (1.1250.2)

 (sayu):  (3.3768.3)

⁴ Tumurtogoo, D. (2006). *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries)*. Taipei, Taiwan.

⁵ Лувсанданзан. (2021). *Эртний хадын үндэслэсэн төр ёсыг товчлон хураасан алтан товч хэмээх оршив*. Улаанбаатар.

⁶ Цэцэн-Мөнх. (2002). *Гэсэрийн бүрэн бичиг* (тэргүүн боть). Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо.

⁷ *Таван зүйлийн үсгээр хавсаргасан манж үгийн толь бичиг*. 1957. Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо.

⁸ умартах: мартах, аливаа өнгөрсөн хэрэг, юмыг санаж олохгүй болох

⁹ өмхий, ялзармал муухай үнэр буюу санааны муу гэх утгатай.

Иймээс XVIII зууны монгол хэл аялгуунд “мэхэй” (mekei) хэмээх үг нэгэнт хэрэглэгдэх болжээ. Энэ бол хэлний хөгжлийн явцад hūmekei (ᠬᠡᠮᠡᠬᠡᠢ) (өмхий) -ийн үгийн эхний төвөнхийн шүргэх гийгүүлэгч h гээгдэн, дараа нь эгшиг ü гээгдэж буй болсон үг юм.

Орчин цагийн монгол хэлэнд жаахан бяцхан гэсэн утгатай “өчүүхэн” хэмээх үг дундад эртний монгол хэлэнд бас “цөөн” гэх утгаар хэрэглэгджээ. Жишээлбэл, “Мукадимат Ал-Адаб монгол хэлний толь” (Хас-Эрдэнэ, 2020: 211) -д “өчүүхэн төрүүлэх эм” нь “цөөн төрсөн эм” гэх утгыг илтгэнэ. Энд “өчүүхэн” нь “цөөн” гэх утгыг илтгэхийн зэрэгцээ дуудлага нь үгийн эхэнд төвөнхийн шүргэх гийгүүлэгчтэй ‘hücüken’ гэдэг үг болно. Цэцэнцогт (1988: 462) тус үгийн утгыг 1) жаахан бяцхан (өчүүхэн цас) 2) мөхөс доод (өчүүхэн миний бодол) 3) цөөн (өчүүхэн төдий) 4) жижиг (өчүүхэн дусал ус) гэж тайлбарласан бөгөөд “өчүүхэн” ба “цөөхөн” нь гарал нэгтэй гэж үзсэн байна. Тэгээд авианы талаар oʃu ~ oʃuxən ~ xoʃuxən гэж эртний дуудлагыг нь сэргээжээ. Одоо ордос аман аялгуунд цөөнийг [oʃo:n] гэж хэлдэг. Тус үг монгол төрөл хэлэнд төвөнхийн шүргэх гийгүүлэгчтэй хэлэгддэгээс харвал ‘höcüken’-ий төвөнхийн шүргэх h авиа нь эхлээд гээгдэж, дараа нь ö эгшиг нь гээгдсэний дүнд ёoken болжээ. Гэвч дундад эртний монгол хэлэнд “өчүүхэн”, “цөөн” нь адил хэрэглэгддэг бөгөөд утгын талаар нарийн ялгаатай байна.

Дундад эртний монгол хэлэнд хэрэглэгдэх давтамж өндөртэй сул үг болох ‘эл’ нь “Монголын нууц товчоон” -д 额列 (эл)¹⁰ хэлбэр 36 удаа илэрдэг. Уйгаржин монгол үсгийн сурвалж бичигт мөн “ᠡᠯ” хэлбэрээр 108 удаа илэрчээ. XVII зуун болоход энэ үг хувирч үгийн эхний e эгшиг нь гээгдэн орчин цагийн монгол хэлний хүч нэмэгдүүлэх сул үгтэй адил хэлбэртэй “ᠡᠯ” болж эхэлжээ. Жишээлбэл, Лувсанданзаны “Алтан товч” (2021) -д “Эсэн тайш гэртээ ирсний хойноо тайшийн эх нь олзгүй. Мэнд л (ᠮᠡᠨᠳᠡᠯᠡ mendüle) байнам гэж хэлэв (152.8)” гэх мэт. Нэн ялангуяа тухайн үеийн ярианы хэлний онцлогийг тусгасан XVIII зууны сурвалж бичиг “Гэсэрийн бүрэн бичиг” (2002) -т хүчин нэмэгдүүлэх сул үг “ᠡᠯ” нийт 16 удаа илэрчээ. Жишээлбэл, “Энэ ахлай бээр чөтгөр биш. Мангас л бий за энэ гэв” (1.20b.09), “Мөр дээр чинь олон чихтэй л байж баригданам за гэв. (5.36a.04)” гэх мэт. Энэхүү үзэгдлийн тухай Б.Я. Владимирцов (1988: 97) “Өгүүлбэрт түргэн уншихаас болж зарим үгсийн авиа эвдэрч, үгийн өргөлт нэгдүгээр үед биш харин хоёрдугаар үед тусдгаас болж нэгдүгээр үеийн эгшиг гээгджээ” гэж үзээд орчин цагийн монгол хэлний ‘үнээрэн~нээрэн, агсан, ажгуу ~ санжээ’ гэх мэтээр жишээлжээ.

5.2. Монгол хэл аялгуу дахь үгийн эхний эгшгийн гээгдэл

Бичгийн хэлэнд үгийн эхний эгшгийн гээгдэх үзэгдэл ордос аман аялгуу, ойрад аялгуу, халх аялгуунд түгээмэл тохиолдоно. Үүнд ордос аман аялгууны үгийн өргөлтийн тухай ямагт нэгдүгээр үед байх буюу тогтмол нэгдүгээр үед байдаггүй гэх харилцан ялгаатай саналууд бий. Цана (2013: 116) авианы дуун ухааны задлалаар ордос аман аялгуунд богино эгшгээр бүтсэн хоёр ба гурван

¹⁰ хүчин нэмэгдүүлэх сул үг ‘л’

үет үгийн өргөлт хоёрдугаар үедээ байдаг. Гэвч урт эгшиг байвал өргөлт урт эгшигт ноогдоно гэх дүгнэлтийг гаргажээ. Үүнээс болж ордос аман аялгуу (Соном, 1999)-нд үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл нэлээд түгээмэл оршдог бөгөөд голдуу *i*, *u*, *ü* зэрэг уйтан эгшигт гол төлөв хамаарна.

ордос аман аялгуу	монгол хэл	ордос аман аялгуу	монгол хэл
xona	ухна	ʃʊgɖur	өчигдөр
muki:	өмхий	xos	ухас
ɖʒu:rsu	үзүүрс	gʊaxʊ	угаах
de	идээ	nɔ:gdɔx	оногдох

Иймэрхүү байдал ойрад аялгуунд бас илэрнэ. Жишээлбэл, [gɔlz] (угалз), [na:l] (инаруу) гэх мэт. Ордос аман аялгуунд эртний монгол бичгийн хэлний үгийн эхний зарим эгшигийг хадгалсаар байгаа үзэгдэл бий (Соном, 1999: 10). Бас бичгийн хэлний гийгүүлэгчээр эхэлсэн үгийн өмнө зохих эгшиг байдаг нь эртний монгол хэлний хэлбэрийг хадгалж байгаа үзэгдэл юм. Жишээлбэл, цөөн [oʃo:n], таана [ɔta:na], сүү [usu] гэж авиалдаг. Мөн ойрад аялгуунд зүг [yɖzyg], сүү [ysyn], үгүй [gɔ:] гэж хэлдэг (Чойжинжав, Н. Гэрэлт, 1998)¹¹. Үүнээс гадна умартахыг *мартах*, сүүг *үсэн*, оногдохыг *ногдох*, үзгийг *зүг*, авгайг *гуай*, үнэхээрийг *нээрэн* гэх мэтээр хэлдэг үзэгдлийн тухай Б.Ринчен (1956: 230) “Монгол бичгийн хэлэнд их төлөв уруул цорвойх эгшгээр эхэлсэн үгэнд гол өргөлт нь дэд үед шилжиж, өргөлтгүй болсон тэргүүн үе нь хожим гээгдэхэд хүрсэн зүйл үзэгдмүй” гэжээ.

Монгол хэл ба дагуур хэлний өргөлт үгийн эхний үед байдаг атал баоань хэл, монгор хэл, зүүн ёгор хэл болон дуншаан хэлний өргөлт үгийн эцсийн үед байдаг төрөл хэлний өргөлтийн байрын иймэрхүү адил бус үзэгдлийг Жүнжийн вен (1997: 55) хэлний ойртолт болсон үзэгдэл гэж үзсэн байна. Шинжаан Уйгарын өөртөө засах оронд уйгар, казах, киргиз, татар, узбек зэрэг олон түрэг төрөл хэл оршиж байдаг. Түүхэн урт хугацаанд Шинжаан, Хөхнуур, Гансу зэрэг газар орших монгол төрөл хэлтэн ба түрэг төрөл хэлтний хоорондох харилцаа холбоо болон соёлын солилцол нь аажмаар хэлний харилцан нөлөөллийг нэмэгдүүлж, адил төрөл хэлний дотоодын хувирал, өөрчлөлт адил бус төрөл хэлний хоорондох газар зүйн нийтлэг шинжийг бий болгожээ. Иймээс баоань, монгор, зүүн ёгор хэл болон дуншаан хэлний үгийн өргөлт үгийн эцсийн үед байрладаг нь түрэг төрөл хэлний нөлөөллийг тусгаснаас болжээ.

Үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл монгол төрөл хэлнээс гадна түрэг төрөл хэлэнд мөн илэрнэ. Ү Хонвей (1995: 71) түрэг төрөл хэлнүүд хүчлэх өргөлт, эгшиглэх өргөлт ба хэмжээт (авианы урт охор) өргөлттэй бөгөөд хүчлэх өргөлт голлох байранд байж, голдуу үгийн эцсийн үед илэрнэ гэжээ. Уйгар сурвалж бичигт суурилж Жан Тэй Шан (2003: 133) уйгар хэлний өргөлтийн тухай судлаад, тус хэлний өргөлтийг анхандаа үгийн эхэнд байснаа шилжиж үгийн эцсийн үед илрэх болсон бөгөөд алтай язгуур хэлний үгийн өргөлт нь нэгдүгээр үеэс үгийн эцсийн үед шилжиж байгаа хувирлын явц мөн гэсэн үзлээ дэвшүүлэв.

¹¹ Чойжинжав, Гэрэлт. Н., (1998). *Ойрад аялгууны үгс*. Хөххот, Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо.

Иймээс түрэг төрлийн хэлэнд монгол хэлтэй тохирох зарим үгийн эхний эгшиг цаашилбал, нэгдүгээр үе бүхлээрээ гээгдсэн үзэгдэл түгээмэл оршдог. Жишээлбэл,

Түрэг	Казах	Киргис	Узбек	Татар	Тува	Монгол
vuldza	quldza	quldza	vuldze	quldza	vuldza	угалз
kul	qul	qul	qul	qul	kul	боол
yer	dzer	dzer	jer	dzer	dzer	газар
kabir	kør	kør	gør	gør	—	хүүр
kör	kor	kør	kor	soqər	sovət	сохор
su	suw	suu	—	su	suw	ус

(Г. Зоригт, 2000: 324)

Үүнээс гадна чуваш хэлэнд olug- (суух) -г lar-аар, eläk-(торх)-г lek -аар, татар хэлэнд ujeqla- (унтах)-г jeqla-аар, якут хэлэнд ujät- (ичих)-г sät-аар, балгар хэлэнд ugu (үр)-г rü гэж дууддаг. Үүний тухай Н.Поппе “Үгийн эхний гийгүүлэгч гээгдэхээс өмнө нэгэнт нэгдүгээр үеийн эгшигээ хамгаалж дийлэхгүй болжээ” гэсэн байна (2004: 169). Уйгар сурвалж бичигт суурильж, Жан Тэй Шан өргөлтийн тухай судлаад, тус хэлний өргөлт анхандаа үгийн эхэнд байснаа шилжиж үгийн эцсийн үед илрэх болсон бөгөөд алтай язгуурын хэлний үгийн өргөлт нь нэгдүгээр үеэс үгийн эцсийн үед шилжиж байгаа хувирлын явц мөн гэж өгүүлжээ (2003: 133).

Манж түнгүс төрөл хэлэнд өргөлт оршихоор барахгүй бас утга ялгах үүрэгтэй (Жао жие, 1989: 74) ба үгийн эхний эгшиг бараг гээгддэггүй байна. Манж бичгийн хэлний өргөлт үгийн эцсийн үед байдаг. Иймээс авианы өндөр нь хоёр үет үгэнд сул-чанга буюу гурван үет үгэнд сул-сул-чанга бүтэцтэй. Гэвч Чин улсын үеийн Бээжин, найман хошуун ¹²-ы манж хэлэнд хоёр үеэр бүтсэн үгийг дуудахад эхний үеийн эгшиг чанга дуудагдан дараах үеийн эгшиг сулаар дуудагдаж чанга-сул хэлбэрээр илрэх буюу гурван үет үгэнд чанга-сул-чанга хэлбэрээр илэрдэг. Иймэрхүү өмнө нь чанга, хойно нь сул хэлбэрийн өргөлт илрэх нь боомтод орохоос өмнөх¹³ үеийн манж хэлний өргөлтийн байр урагш шилжсэн үзэгдэл болох бөгөөд манж баримжаа хэл ба аман аялгууны ялгаа болно (Жао жие, 1995: 23). Үүний а, о чанга эгшиг, э, и, о хөндий эгшиг, i саармаг эгшиг байж амны нээлтийн хэмжээ нь авианы хүчдлийн чанга сулыг тогтооно. Даруй хэлний байр хэдий нам бол төдий чанга авиалагдаж, хэдий өндөр бол төдий сул авиалагдана (Жао жие, 1995: 23).

¹² Найман хошууны дүрэм: Манж үндэстний нийгмийн амьдрал ба цэрэг засгийн хамаарлын дүрэм, даруй шулуун шар, шулуун цагаан, шулуун улаан, шулуун хөх, хөвөөт шар, хөвөөт цагаан, хөвөөт улаан, хөвөөт хөх зэрэг тугны өнгөөр нэрийдсэн найман хошууны дүрмийг хэлнэ.

¹³ Чин Улсын цэрэг 1644 онд шанага (山海关) боомтод орж Бээжинг эзлэхээс өмнөх үе.

6. Дүгнэлт

Үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл бол алтай язгуурын хэлний нийтлэг онцлог мөн. Үүнд, монгол төрөл хэл болох дагуур ба монгол хэлэнд үгийн эхний эгшиг гээгдэх үзэгдэл нь тун цөөн тохиолдож, харин зүүн ёгор хэл, монгол хэл ба баоань хэлэнд эгшиг гээгдэх үзэгдэл түгээмэл илэрдэг. Үгийн эхний эгшиг гээгдэхэд эгшгийн аниршил, холбогдол бүхий гийгүүлэгчийн шинж, жич, үгийн өргөлтийн байр чухал нөлөө үзүүлдэг.

Нэгдүгээрт, өргөлтөөс болж аниршсан үгийн эхний эгшиг дуугүй, тодорхой бус, хүчдэл сул зэрэг онцлогтой байдаг бөгөөд энэхүү аниршсан эгшиг хэл ярианы орчинд авиалбарын шинжээ алдаад аажмаар гээгддэг байна.

Хоёрдугаарт, хамрын гийгүүлэгч n өмнөх эгшгийн хэлний байрыг өндөржүүлэн ижилшүүлж аниршуулахад хамжих ба хамжин шүргэх гийгүүлэгч нь өгүүлэх эрхтэнд харш саад учруулах хугацааг уртасгаж хойнох эгшгийн авианы уртыг богиносгон аниршуулдаг.

Гуравдугаарт, үгийн үеийн байдлаас ажиглавал, баоань хэлэнд үгийн эхний эгшиг бүтцэт үеийн эгшиг гээгдэх нь тооны харьцаагаар илүү байхад монгол хэл ба зүүн ёгор хэлэнд гийгүүлэгч эгшиг бүтцэт үеийн эгшиг гээгдэх нь олон байдаг. Монгол төрөл хэлний үгийн эхэнд гээгдсэн эгшиг нь голдуу монгол бичгийн хэлний уйтан эгшиг i ба уруулын эгшиг u, \bar{u} -тай тохирно. Энэ нь амны хөндий уйтан байдаг эгшгийн авианы хүчдэл сул байдагтай шууд холбоотой.

Баоань хэл, монгол хэл, зүүн ёгор хэл ба дуншаан хэлний өргөлт үгийн эцсийн үед байрладаг нь түрэг төрлийн хэлний нөлөө орсон хэлний ойртолцлын үр дүн мөн. Үүнээс болж адилхан нэг монгол төрөл хэлэнд багтах эл хэлний үгийн өргөлтийн байрын адил бус шинж, жич, монгол төрөл хэл, түрэг төрөл хэл зэрэг адил бус төрөл хэлний үгийн өргөлтийн байрын газар зүйн нийтлэг шинжийг буй болгожээ. Түрэг төрөл хэлэнд үгийн өргөлт мөн үгийн эцсийн үед илэрч үгийн эхэнд эгшиг гээгдэх үзэгдэл оршино.

Монгол хэл ба дагуур хэлний үгийн өргөлт ихэнхдээ нэгдүгээр үед байдаг учир үгийн эхэнд эгшиг гээгдэх үзэгдэл тун цөөн илэрдэг. Үүнд монгол сурвалж бичигт илэрдэг “умартах”, “өмхий”, “өчүүхэн”, “эл” зэрэг үгийн буюу одоо гийгүүлэгчээр эхэлдэг үгийн эхэнд эгшиг угтварлан бичигдэж байсан бөгөөд ордос, ойрад зэрэг монгол хэл аялгуунд бичгийн хэлний эгшгээр эхэлсэн үгийн эгшиг гээгдэх үзэгдэл бас түгээмэл илэрнэ.

Манж түнгүс төрөл хэлэнд үгийн өргөлт утга ялгах үүрэгтэй ч үгийн эхний эгшиг гээгддэггүй. Иймээс алтай язгуурын хэлний үгийн өргөлтийг орон зайн талаас шинжилж үзвэл, манж түнгүс төрөл хэл, монгол төрөл хэл ба түрэг төрөл хэлний үгийн өргөлт нь газар зүйн байршлын хувьд ерөнхийдөө зүүнээс баруунш чиглэлийн дагуу өргөлтийн байр нь үгийн эхний үеэс эцсийн үе рүү шилжсэн байна. Үүний дагуу алтай язгуур хэлний үгийн эхний эгшиг гээгдэх хэмжээ ч зүүнээс баруунш чиглэл дагуу аажмаар нэмэгджээ.

Ном зүй

- Алтансүвд.** (2023). *Зүүн ёгор хэлний амь ахуйн хэл шинжлэлийн судлал*. Хөххот, Өвөрмонголын их сургуулийн хэвлэлийн хороо. [Altansuvd. *Züün yogor khelnii ami akhuin khel shinjleliin sudlal*. [An Ecolinguistic Study of Eastern Yugur]. Inner Mongolia University Press. Hohhot, 2023]
- Булчулуу, Залсан.** (1991). *Зүүн ёгор хэл ба монгол хэл*. Хөххот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Bulculuu, Jalsan. *Züün yogor khel ba mongol khel*. [Eastern Yugur and Mongolian]. Inner Mongolia People's Publishing House. Hohhot, 1991]
- Бөхөө.** (1986). *Дуншаан хэл ба монгол хэл*. Хөххот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Bokhoо. *Dunshyan khel ba mongol khel*. [Dungxiang and Mongolian]. Inner Mongolia People's Publishing House. Hohhot, 1986]
- Зоригт, Г.** (2000). *Монгол төрлийн хэл ба түрэг төрлийн хэлний үгсийн харьцуулсан судлал*. Хөххот, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. [Jorigt, G. *Mongol törliin khel ba türeg törliin khelnii ügsiin kharitsuulsan sudlal* [A Comparative Study of Mongolic and Turkic Lexicon]. Inner Mongolian Education Publishing House. Hohhot, 2000]
- Хас-Эрдэнэ.** (2020). *Мукадимат Ал адаб - Монгол хэлний толь*. Шэньян, Ляонингийн үндэстний хэвлэлийн хороо. [Has-Erdene. *Mukadimat Al adab- Mongol khelnii toli*. [Mukadimat al-Adab Mongolian Dictionary]. Liaoning Nationalities Publishing House. Shenyang, 2020]
- Хасбагана.** (2014). *Монгол хэлний түүхэн улирал хувирал хийгээд сурвалж бичгийн судлал*. Хөххот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Hasbagana. *Mongol khelnii түүхэн улрал khuviral khiiгеед surbalj bichgiin sudlal*. [The Historical Evolution of Mongolian Script and Manuscript Studies]. Inner Mongolia People's Publishing House. Hohhot, 2014]
- Хасхүү.** (2014). *Авианы дуун ухааны дата хөмрөгт суурилсан зүүн ёгор хэлний эгшгийн судалгаа*. Хөххот, Өвөр Монголын их сургууль. [Haskhuu. *Aviany duun ukhaany data khömrögt suurilsan züün yogor khelnii egshgiin sudalгаа*. [A Study of Vowels in Eastern Yugur Based on a Phonetic and Acoustic Database]. Inner Mongolia University. Hohhot, 2014]
- Цэцэнцогт.** (1988). *Монгол үгсийн язгуурын толь*. Хөххот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Tsetsentsogt. *Mongol ügsiin yazguuryн toli*. [A Dictionary of Mongolian Roots]. Inner Mongolia People's Publishing House. Hohhot, 1988]
- Соном.** (1999). *Ордос аман аялгууны үгсийн хураангуй*. Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо. [Sonom. *Ordos aman ayalguuny ügsiin huraangui*. [A Lexicon of the Ordos Dialect]. Nationalities Publishing House. Beijing, 1999]
- Цана.** (2013). *Монгол хэлний ордос аман аялгуу ба баримжаа авианы дуун ухааны харьцуулал*. Хөххот, Өвөр Монголын их сургууль. [Cana. *Mongol khelnii ordos aman ayalguu ба barimжаа авiany duun ukhaany харitsuулал*. [An Acoustic Comparison of the Ordos Dialect and Standard Mongolian]. Inner Mongolia University. Hohhot, 2013]
- Цэнгэлдэй.** (1991). *Монгор хэл ба монгол хэл*. Хөххот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. [Tsengeldei. *Mongor khel ба mongol khel*. [Mongor and Mongolian]. Inner Mongolia People's Publishing House. Hohhot, 1991]

- Ринчен, Б.** (1956). *Монгол хэлний зүйн бичиг (дээд дэвтэр)*. Улаанбаатар. [Rinchin, B. *Mongol khelnii züin bichig (deed devter)*. [Mongolian Grammar (Vol. 1)] Ulaanbaatar, 1956]
- Чен Най Шион.** (1995). 陈乃雄论文集. 内蒙古教育出版社, 呼和浩特. Чен Най Шионгийн өгүүллийн түүвэр. *Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо*. [Chen nai xiong. Chen nai xiong lun wen ji. [Collected Papers of Chen Naixiong]. *Inner Mongolia Education Press. Hohhot*, 1995]
- Дээжхүү.** (2017). 基于语音声学参数库的保安语元音研究 (硕士学位论文), 西北民族大学, 兰州. Баоань хэлний эгшигт дуун ухааны задлал. Ланжоу. *Баруун Хойдын Үндэстний их сургууль*. [De ge ji hu. ji yu yu yin sheng xue can shu ku de bao an yu yuan yin yan jiu. [A Study of Baoan Vowels Based on an Acoustic Parameter Database. Master's thesis]. *Northwest Minzu University. Lanzhou*, 2017]
- Владимирцов, Б. Я.** (1988). 蒙古书面语与喀尔喀方言比较语法, 青海人民出版社, 西宁. Монгол бичгийн хэл ба халх аялгууны харьцуулсан судалгаа. *Хөхнуур ардын хэвлэлийн хороо*. [fu la ji mi er zuo fu. meng gu shu mina yu yu ka er ka fang yan bi jiao yu fa. [A Comparative Grammar of Written Mongolian and the Khalkha Dialect]. *Chinghai People's Publishing House*. 1988]
- Хан Гүө Жиүн.** (2013). 基于语音声学参数库的土族语元音研究 (硕士学位论文), 内蒙古大学, 呼和浩特. Авианы дуун ухааны дата хөмрөгт суурилсан монгол хэлний эгшигийн судалгаа. *Хөххот. Өвөр Монголын их сургууль*. [Han guo jun. Ji yu yu yin sheng xue can shu ku de tu zu yu yuan yin yan jiu. [A Study of Tu (Monguor) Vowels Based on an Acoustic Parameter Database]. *Inner Mongolia University. Hohhot*, 2013]
- Поппе, Н.** (2004). 阿尔泰语比较语法, 内蒙古教育出版社, 呼和浩特. Алтайн хэлний харьцуулсан хэлний зүй. *Хөххот, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо*. [Bao pei. A er tai yu bi jiao yu fa. [Comparative Grammar of the Altaic Languages]. *Inner Mongolian Education Press. Hohhot*, 2004]
- Жан Тэй Шан.** (2003). 论回鹘文文献语言的词重音, 新疆大学学报 03. Уйгур сурвалж бичгийн хэлний үгийн өргөлт. *Шинжаан их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*. 03. [Zhang tie shan. lun hui hu wen wen xian yu yan de ci zhong yin. [On Word Stress in the Language of Old Uighur Documents]. *Journal of Xinjiang University*, 2003]
- Ү Хонвей.** (1995). 突厥语族语言的词重音问题, 民族语文 05. Түрэг төрөл хэлний өргөлтийн асуудал, *Үндэстний хэл бичиг*. 05. [Wu hong wei. Tu jue yu zu yu yan de ci zhong yin wen ti. [Word Stress in Turkic Languages]. *Minority languages of China*, 1995]
- Жао жие.** (1989). 现代满语研究, 民族出版社. Одоо үеийн манж хэлний судлал, *Үндэстний хэвлэлийн хороо*. [Zhao jie. xian dai man yu yan jiu. [Studies on Modern Manchu]. *Nationalities Publishing House. Beijing*, 1989]
- Жао жие.** (1995). 清初满语京语重音前移及其对京腔汉语的影响, 满语研究 01, Чин Улсын эхний үеийн манж хэлний Бээжин аялгууны өргөлтийн өмнөш шилжил, жич Бээжин аялгууны хятад хэлэн дэх нөлөөлөл. *Манж хэл*

судлал. 01. [Zhao jie. Qing chu man yu jing yu zhong yin qian yi ji qi dui jing qiang han yu de ying xiang. [The Advancement of Word Stress in Early Qing Manchu Mandarin and Its Influence on Beijing Chinese]. *Manchu Studies*. 01.1995]

Жүнжийн вен. (1997). 甘青地区突厥蒙古诸语言的区域特征. 民族语文. 04. Гансу, Хөхнуурын түрэг төрөл хэл ба монгол төрөл хэлний газар орны онцлог. *Үндэстний хэл бичиг*. 04. [Zhong jin wen. Gan qing di qu tu jue meng gu zhu yu yan de qu yu te zheng. [Areal Features of Turkic and Mongolic Languages in the Gansu - Qinghai Region]. *Minority languages of China*.04.1997]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>